



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Эрх зүйн маргааны харьяалал тогтоолгох
тухай хүсэлтийг хангахаас
татгалзах тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар

Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга, итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх И.Мөнхжаргалаас ирүүлсэн “Эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгох тухай” хүсэлтийг шүүгч Д.Батбаатарын танилцуулснаар хянан хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Хүсэлт гаргагч Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга, итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх И.Мөнхжаргал 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 02/192 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтдээ: “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25.7.4-т “хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох”, 26.1-д “Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 25.7.3, 25.7.4, 25.8-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргана” гэж тус тус заасны дагуу дараах эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор хүсэлт гаргаж байна.

Нэг. Ардчилсан намыг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очир нь Улсын дээд шүүхэд холбогдуулж үндэслэл, нотолгоог дурдан дараах нэхэмжлэл, нэхэмжлэлийн шаардлагыг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан. Үүнд: Монгол Улсын дээд шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн нийт шүүгчийн хуралдааны Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хуульд нийцсэн гэж үзэн уг дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн хэсгийг хууль бус болохыг тогтоож, уг хурлаас гарсан 12 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах гэсэн хэдий ч Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн “Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах тухай” 3986 дугаар захирамж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн “Нэхэмжлэл хүлээн авахаас татгалзах шүүгчийн захирамжийг хэвээр үлдээх тухай” 462 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54.1.1 буюу “захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус” гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

Хоёр. Ардчилсан намыг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ган-Очир нь Улсын дээд шүүхэд холбогдуулж үндэслэл, нотолгоог дурдан дараах нэхэмжлэл, нэхэмжлэлийн шаардлагыг Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны

шүүхэд гаргасан. Үүнд: Монгол Улсын дээд шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн нийт шүүгчийн хуралдааны Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хуульд нийцсэн гэж үзэн уг дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн хэсгийг хууль бус болохыг тогтоож, уг хурлаас гарсан 12 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах гэтэл Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн “Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай” 182/Ш32022/10274 дүгээр захирамжаар “шүүх иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэр, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийг шалгах бөгөөд хэрэв нэхэмжлэл хуульд заасан шаардлага хангаагүй бол шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана”, Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “...бүх шатны шүүх, прокуророос хуульд заасан эрх мэдэл буюу хууль тогтоох, гэмт хэрэг, эрх зүйн маргаан хянан шийдвэрлэх онцгой бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрээс бусад захиргааны чиг үүрэг, шийдвэртэй нь холбогдуулан уг байгууллагыг захиргааны байгууллагад тооцно”, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8-д “Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 25.8.8-д “улс төрийн намын бүртгэл хөтлөх” гэж тус тус заажээ.

Дээрх хуулийн агуулгаас гэмт хэрэг эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх нь бүх шатны шүүхийн онцгой бүрэн эрх бөгөөд бусад захиргааны чиг үүрэг, шийдвэртэй нь холбогдуулан захиргааны байгууллагад тооцогдохоор байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлд иргэний хэрэг үүсэх үндэслэлийг дурдсан ба 12.1.4-т “Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол,” гэжээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д зааснаар тус нэхэмжлэл нь иргэний хэргийн шүүх харьяалан шийдвэрлэх нэхэмжлэлд хамаарахгүй, нэхэмжлэгч нь хэргийн харьяалал зөрчсөн байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, 65.1.1, 65.1.5-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зүйтэй гэж үзэв хэмээн шийдвэрлэсэн.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 28.1.1-т “хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллыг тогтоох” гэж заасны дагуу Улсын дээд шүүхийн захиргааны танхимд хандан хэргийн харьяалал тогтоолгохоор хүсэлт гаргасан боловч тус Танхимын тэргүүн Д.Мөнхтуяа нь 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 04/3609 дүгээр албан бичгээр “... Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоолыг хянах эрх хэмжээг анхан болон давж заалдах шатны шүүхэд хуулиар олгоогүй тул хэргийн харьяалал нь тодорхойгүй буюу хэргийн харьяалал тогтоох шаардлага үүссэн гэж үзэхгүй, ... хэргийн харьяалал тогтоох хууль зүйн үндэслэлгүй...” гэх ойлгомжгүй хариуг ирүүлсэн.

Гурав. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1.3-т ““нэхэмжлэл” гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг”, 13.1-д “Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж заасан атал захиргааны хэргийн анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүхээс тухайн маргаан нь захиргааны хэргийн харьяаллын бус буюу Улсын дээд шүүх нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасан захиргааны байгууллага биш хэмээн үзсэн.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.2-т “Нэхэмжлэгч гэж хуульд заасан эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж эрхээ сэргээлгэхээр өөрийн болон бусдын нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргагч этгээдийг хэлнэ” гэж заасны дагуу нэхэмжлэгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12.4-т заасан эрхийн хүрээнд нэхэмжлэл гаргасан боловч иргэний шүүхээс иргэний маргаан бус Улсын дээд шүүх нь дээрх тохиолдолд захиргааны байгууллага мөн учир захиргааны маргаан хэмээн үзэв.

Шүүхийн тухай хуулийн 6.1-д “Хууль дээдлэх нь шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” хэмээн заасан атал захиргааны хэргийн шүүх нь тухайн маргааныг захиргааны шүүхийн харьяаллын бус, иргэний хэргийн шүүх нь иргэний хэргийн харьяаллын бус захиргааны маргаан байна хэмээн үзэж хууль зүйн хувьд хуулийн этгээд зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрх эдлэх боломжгүй харьяаллын ойлгомжгүй байдал үүсгээд байна. Иймд эрх зүйн маргааныг шийдвэрлэх шүүхийн хэргийн харьяаллыг тогтоож өгнө үү” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

2.Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга, итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх И.Мөнхжаргалаас Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд ирүүлсэн “Хэргийн харьяалал тогтоолгох тухай” хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэлээ.

3.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 3986 дугаар захирамжаар “Ардчилсан намаас “Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хуульд нийцсэн гэж үзэн уг дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн” нь хууль бус болохыг тогтоож, нийт шүүгчийн хуралдааны 12 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах” тухай нэхэмжлэлийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д “захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус” гэж заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзсаныг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 462 дугаар тогтоолоор хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

4.Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 182/Ш32022/10274 дүгээр захирамжаар Ардчилсан намын “Улсын дээд шүүхийн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн нийт шүүгчийн хуралдааны Ардчилсан намын Үндсэн дүрмийн нэмэлт, өөрчлөлт нь Улс төрийн намын тухай хуульд нийцсэн гэж үзэн уг дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн нь хууль бус болохыг тогтоож, уг хурлаас гаргасан 12 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах” тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.5-д заасан үндэслэлээр мөн хүлээн авахаас татгалзжээ.

5.Хүсэлт гаргагч И.Мөнхжаргалаас ирүүлсэн “Эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгох тухай” хүсэлтийг Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцээд хүсэлтэд дурдсан нэхэмжлэлийг шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр хэргийн харьяалал тогтоох хууль зүйн үндэслэлгүй, хүсэлтийн хариуг Танхимын тэргүүн хүргүүлэх нь зүйтэй” гэж үзсэн, улмаар Захиргааны хэргийн Танхимын тэргүүн “нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамжийг хянасан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр бөгөөд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоолыг хянах эрх хэмжээг анхан болон давж заалдах шатны шүүхэд хуулиар олгоогүй тул хэргийн харьяалал нь тодорхойгүй буюу хэргийн харьяалал тогтоох шаардлага үүссэн гэж үзэхгүй” талаар 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 04/3609 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлсэн байна.

6.Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль, энэ хуультай нийцэж байгаа эсэхэд Улсын дээд шүүх хяналт тавина. Нам өөрийн дүрэм, мөрийн хөтөлбөртөө оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 10 хоногийн дотор Улсын дээд шүүхэд бүртгүүлнэ”, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 “Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ... 25.8.8 улс төрийн намын бүртгэл хөтлөх”, 26 дугаар зүйлийн 26.1-д “Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар энэ хуулийн 25.7.3, 25.7.4, 25.8-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргана” гэж заасны дагуу улсын төрийн намын дүрэм, мөрийн хөтөлбөртэй холбоотой асуудлыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж тогтоол гаргадаг.

7.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно.” гэх заалтаас үзвэл улс төрийн намын дүрэм, мөрийн хөтөлбөр, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль, хуультай нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж бүртгэх эсэхийг шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр бөгөөд түүнийг хуульд харшилсан гэж үзвэл Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгох эрхтэй. Бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлэх үүрэгтэй байна.

8.Эндээс дүгнэвэл Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга, итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх И.Мөнхжаргалын Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах тухай” хүсэлтийг харьяалал нь тодорхойгүй буюу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7./Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ...25.7.4.хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;/-д хамааруулж харьяалал тогтоох үндэслэлгүй.

9.Иймд Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга, итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх И.Мөнхжаргалын “хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгох тухай” хүсэлтийг хангахаас татгалзах нь зүйтэй гэж үзэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.4-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга, итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх И.Мөнхжаргалын “Эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгох тухай” хүсэлтийг хангахаас татгалзсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ШҮҮГЧ

Д.БАТБААТАР